



ДАЛАЙВАН АУДИТ

Аудиторын тайлан

“ЭРЭЛ” БАНКНЫ 2004 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР
БОЛГОСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН



ДАЛАЙВАН АУДИТ ХХК

Нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөө, аудит, үнэлгээний
итгэмжлэгдсэн байгууллага

Монгол улс, Улаанбаатар хот
Амарсанаагийн гудамж
Далайван Аудит компанийн байр
Утас: 305401, 305402, 305404, 305405
Факс: 976-1-305403
E-mail: info@dalaivanaudit.mn
Вэб хуудас: dalaivanaudit.mn

“ЭРЭЛ” банкны хувь нийлүүлэгч
Д.Сэргэлэн танаа

Аудиторын тайлан

2004 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн танай банкны жилийн баланс, орлого үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, банкны үйл ажиллагааны зохицой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангуудыг хүлээн авч танилцлаа. Эдгээр тайлангуудыг бэлтгэн гаргах нь банкны удирдлагын хариуцлага бөгөөд бидний хариуцлага бол энэхүү тайлангуудад хийсэн аудитаа үндэслэн аудиторын дүгнэлт өгөх явдал юм.

Бид аудитын ажлаа Аудитын олон улсын стандартад нийцүүлэн, Монгол улсын аудитын тухай хуулийн дагуу явуулав. Санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэдэг үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитын ажлыг төлөвлөж, тусгайлан боловсруулсан хөтөлбөрийн дагуу асуулга хийх, тулгах, давтан гүйцэтгэх, хөөн шалгах зэрэг аудитын горимуудыг ашиглан, банкны нягтлан бодох бүртгэлийн болон холбогдох бусад баримт материалыг түүвэрлэн шалгаж, дотоод хяналтын систем ба нягтлан бодох бүртгэл хөтлөж буй арга ажиллагааг үнэлсэн. Аудитын ажлын үр дүн нь дараах дүгнэлт гаргах үндэслэл болно гэдэгт бид итгэлтэй байна.

“Эрэл” банкны удирдлагаас бэлтгэн танилцуулсан 2004 оны 12-р сарын 31-нээрх тэнцэл, орлого, зарлага, хуримтлагдсан ашгийн болон мөнгөн хөрөнгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, Банкны тухай хууль болон Монголбанкнаас боловсруулж мөрдүүлсэн нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх заавар журмын дагуу материаллаг зөрчилгүйгээр илэрхийлэгдсэн байна.



2005 оны 01 сарын 31-ний өдөр

**Аудиторын тайлангийн нэмэлт
тайлбар тодруулга.**

**1. Банкны бүтэц зохион байгуулалт,
үйл ажиллагааны чиглэл**

"Эрэл" банк нь 1997 онд байгуулагдсан, Улаанбаатар хотод тооцооны 2 төв, Дархан-Уул аймагт нэг салбартай, нийт 44 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Банкны хувь нийлүүлэгчээс 2004 онд дүрмийн сангийн хэмжээг 450.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 4.0 тэрбум төгрөгт хүргэжээ.

Банкны гүйцэтгэх захирлын 2004 оны 54 тоот тушаалаар "Мөнгөн хадгаламж барьцаалан олгох зээлийн хүүгийн хэмжээ"-г өөрчлөн 2004 оны 07-р сарын 01-ний өдрөөс, 77 тоот тушаалаар "Банкны зээлийн харилцааг зохицуулах тухай журам"-ыг батлан 2004 оны 09-р сарын 13-ны өдрөөс эхлэн тус тус мөрдөж ажилласан.

Тус банкны гадаад валutyн арилжаа орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Гүйцэтгэх захирлын 2004 оны 66 тоот тушаалаар Банкны хэмжээнд ам.доллараас гадна евро, фунт стерлинг, рубль, юань зэрэг чөлөөтэй хөрөвдөг валютаар хийх арилжааг 2004 оны 07-р сарын 31-ний өдрөөс эхлүүлсэн байна.

Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр "Ажлын байр нэмэгдүүлэх" төслийн хүрээнд тодорхой зориулалтаар, эргэж төлөгдөх хугацаатай, бага хүйтэй зээлийг харилцагч аж ахуйн нэгж, иргэдэд олгожээ.

Банкны бүтцийг 2003 оноос Зээл эдийн засгийн, Бүртгэл тооцооны, Гадаад тооцоо валutyн, Аж ахуй үйлчилгээний хэлтсүүтэйгээр зохион байгуулж, үйл ажиллагаагаа өргөтгөн явуулж байна.

Эрсдлээс хамгаалах, цаашид хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг хангах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2004 оны 05-р сарын 14-ний өдрийн 35 тоот тушаалаар "Актив, пассив эрсдлийн удирдлагын хорооны журам"-ыг батлаж үйл ажиллагаандaa мөрджээ.

Гүйцэтгэх захирлын 2004 оны 84 тоот тушаалаар Эрэл банкны Аж ахуй үйлчилгээний хэлтсийн дүрмийг баталсан ба энэхүү дүрмийг мөрдөн ажиллаж байна.

Аудитын байгууллага, Татварын алба зэрэг холбогдох дээд шатны байгууллагаас хийсэн шалгалтын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, засаж сайжруулах талаар Банкны гүйцэтгэх удирдлагаас тушаал шийдвэр гарган арга хэмжээ авч, ажилтнуудад үүрэг даалгавар өгч, биелэлтэнд нь хяналт тавьж ажилласан байна.

Монголбанкны хяналт шалгалтын газраас “Эрэл” банкны үйл ажиллагаа, санхүү төлбөрийн байдалд “Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг газар дээр нь шалган үнэлгээ дүгнэлт өгөх журам”-ын дагуу ээлжит шалгалтыг хийсэн ба эцсийн үр дүнгийн албан ёсны дүгнэлт нь аudit хийж байх хугацаанд тус банкинд хараахан ирээгүй байсан.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайланг бэлтгэсэн үндэслэл

Монголбанкны ерөнхийлөгчийн 2003 оны 549 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэжээ.

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү эдийн засгийн сайдын хамтарсан 2004 оны 459/207 тоот тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу активыг ангилан, олгосон зээлд болзошгүй эрсдлийн зардлыг тооцжээ.

Санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгыг зохих журмын дагуу хийж хавсаргасан байна.

Санхүүгийн тайланд тусгагдсан дансдын гүйлгээ, үлдэгдлийг үндэсний валют төгрөгөөр илэрхийлсэн ба гадаад валютаар хийгдсэн гүйлгээг Монголбанкнаас тухайн үед зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлэн тусгасан.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг Монгол улсын аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуулинд заагдсан хувь хэмжээг баримтлан шулуун шугамын аргаар байгуулж үйл ажиллагааны зардалд шингээсэн.

Banks бүртгэлийн программ нь бүртгэлийн шаардлага хангахгүй байсны улмаас өмнө ашиглаж байсан “Ня-бо-2” программд эргэн шилжсэн байна. Банкны гүйцэтгэх захирлын 73 тоот тушаалын дагуу 2004 онд нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн сонгон шалгаруулалт явуулж “Интер актив” программыг

ашиглахаар сонгосон бөгөөд одоогоор хамтран ажиллах гэрээ байгуулах ажил хийгдэж байна.

Банкны дотоод хяналтын хэлтсээс Дархан-Уул аймаг дахь салбар болон тооцооны төвүүдэд графикт шалгалтыг хийж, шалгалтын үр дүнгийн талаарх дүгнэлтээ гарган тайлагнаж, илэрсэн зөрчлийг засаж залруулах талаар арга хэмжээ авч иржээ.

3. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн талаар

Мөнгөн хөрөнгө

	2004.12.31	2003.12.31
Бэлэн мөнгө	500,571.3	212,118.6
Монголбанк дахь харилцах	93,799.0	216,540.3
Бусад банк дахь харилцах	44,603.4	95,081.6
Дүн (мянган төгрөөр)	638,973.7	523,740.5

Санхүүгийн тайлан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн дүн нь хураангуй ба дэлгэрэнгүй бүртгэл, тооллогын дүнгийн үлдэгдэлтэй тохирч байна.

Гадаад валютаар хийгдсэн гүйлгээг тухайн өдрийн Монголбанкны албан ханшаар бүртгэж тайлант хугацааны эцэст гадаад валютаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг хаалтын ханшаар хөрвүүлэн олз гарзыг бүртгэжээ.

Төгрөгийн болон гадаад валютын кассын баримтын бүрдэл, хүчин төгөлдөр байдлыг түүвэрлэн шалгахад материаллаг алдаа зөрчил илрээгүй болно.

Зээл

	2004.12.31	2003.12.31
Зээл	4,965,374.3	4,869,940.8
Хэвийн	4,521,584.3	4,555,670.8
Хугацаа хэтэрсэн	-	263,200.0
Чанаргүй	443,790.0	51,070.0
- хэвийн бус	55,710.0	20,800.0
- эргэлзээтэй	96,720.0	3,570.0
- муюу	291,360.0	26,700.0
(ЗТУБАХС)	(431,399.8)	(92,401.7)
Дүн (мянган төгрөгөөр)	4,533,974.5	4,777,539.1

Тайлангийн хугацаанд нийт 4,965,374.3 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаагаас 91.0% буюу 4,521,584.3 мянган төгрөг нь хэвийн зээл, 9.0% буюу 443,790.0 мянган төгрөг нь чанаргүй зээл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт зээлийн үлдэгдэл 95,433.5 мянган төгрөгөөр буюу 2.0%-иар өссөн ба чанаргүй зээлийн дун 392,720.0 мянган төгрөгөөр өссөн байна.

“Эрэл” банк нийт 184 зээлдэгчид 4,965,374.3 мянган төгрөгийн зээл олгожээ. Зээлийн хувийн хэргийн бүрдэлт, зээлийн хорооны хурлын протокол, холбогдох материалтай танилцаж төлөлтийн байдлыг шалгаж үзэхэд зээлийн бодлогын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

“Эрэл” банкны 20 том зээлдэгчийн нийт 3,661,270.3 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл нь нийт зээлийн үлдэгдлийн 73.7%-тай тэнцэж, өөрийн хөрөнгийн 89.8% байгаа нь зээлийн төвлөрөл их байгаа боловч нэг зээлдэгчид олгох зээлийн хязгаарлалтыг “Банкны тухай хууль”-д заасан хэмжээнд хангаж ажилласан.

Тайлангийн хугацаанд зээлийн үлдэгдлийн ангиллыг харгалзан ЗТУБАХ санг Монголбанкнаас шинэчлэн гаргасан журмын дагуу 349,535.2 мянган төгрөгөөр байгуулжээ.

Үнэт металл

	2004.12.31	2003.12.31
Алт	-	4,737.6
Дүн (мянган төгрөгөөр)	-	4,737.6

Тус банк нь Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн дагуу аж ахуйн нэгжүүдээс алт худалдан авч Монголбанкинд борлуулдаг бөгөөд 2004 онд үнэт металлын арилжаанаас 14,331.7 мянган төгрөгийн орлого олж, тайлант хугацааны эцэст үнэт металлын үлдэгдэлгүй байна.

Үнэт цаас

	2004.12.31	2003.12.31
Монголбанкны үнэт цаас	1,100,000.0	900,000.0
Үнэт цаасны хямдруулалт	(2,544.5)	(125.0)
Дүн (мянган төгрөгөөр)	1,097,455.5	899,875.0

Тус банк нь Монголбанкнаас нийт 57 удаагийн арилжаагаар нийт 18,127 ширхэг үнэт цаас худалдан авч 61,249.4 мянган төгрөгийн хүүний орлого олжээ.

Үндсэн хөрөнгө

	2004.12.31	2003.12.31
Орон байшин	101,124.9	101,124.9
Эд хогшил	244,345.4	245,209.9
Компьютер	122,500.1	118,037.2
Хуримтлагдсан элэгдэл	(187,777.1)	(138,850.2)
Үндсэн хөрөнгийн санхүүжилт	261,600.0	260,750.0
Дүн (мянган төгрөгөөр)	541,793.3	586,271.8

"Банкны эд хөрөнгийг захиран зарцуулах" журмын дагуу нийт 7,631.4 мянган төгрөгийн эд хогшил, 5,239.6 мянган төгрөгийн компьютер дагалдах хэрэгсэл худалдан авч, 6,089.8 мянган төгрөгийн эд хогшил худалдсан байна.

Тайлант хугацаанд төв банкнаас Дархан-Уул аймаг дахь салбарт 14,254.1 мянган төгрөгийн, тооцооны хоёрдугаар төвд 2,325.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус шилжүүлсэн.

Дуусаагүй барилга дансанд бүртгэгдсэн Эрэл банкны барилгын ажил тодорхой шалтгааны улмаас зогссон бөгөөд 2004 онд Пүма интернейшил ХХК-р гүйцэтгүүлсэн барилгын салхивчны зураг төслийн үнэ болох 850.0 мянган төгрөгөөр уг дансны үлдэгдлийг нэмэгдүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг эд хогшилд 10%-иар, компьютерт 20%-иар, орон байшинд 2.5%-иар тооцож, тайлантгийн хугацаанд 51,412.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцжээ.

Банкны нийт салбар ба тооцооны төвүүдийн үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг Гүйцэтгэх захирлын 2004 оны 12-р сарын 14-ний өдрийн 88 тоот тушаалын дагуу явуулсан бөгөөд тооллогоор илүүдэл, дутагдал гараагүй байна.

Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө

	2004.12.31	2003.12.31
ӨБҮХХөрөнгө	-	32,452.0
Болзошгүй эрсдлийн сан	-	(324.5)
Дүн (мянган төгрөгөөр)	-	32,127.5

"Бумчин сервис" ХХК-ийн зээлийн барьцааны гэрээнд заасны дагуу хугацаандаа төлөгдөөгүй зээлийн барьцаа хөрөнгийг захиран зарцуулах эрхийг банк шилжүүлэн авч, үндсэн өрийн 32,452.0 мянган төгрөгөөр өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн дансанд бүртгэж, эрсдлийн сан байгуулсан бөгөөд тайлант хугацаанд үндсэн өр болон балансын гадуур бүртгэлтэй байсан зээлийн хүүг төлж барагдуулсан учир өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгөнөөс хассан.

Мөн зээлдэгч Б.Пэрэнлэйгийн зээлийн барьцаа хөрөнгийг захиран зарцуулах эрхийг банк шилжүүлэн авч, үндсэн өрийн 108,180.0 мянган төгрөгөөр өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн дансанд бүртгэж, уг хөрөнгийг иргэн П.Эрдэнэхүягт 2 жилийн хугацаатай санхүүгийн түрээсийн гэрээ байгуулан шилжүүлж, үндсэн өр болон хүүгийн төлбөрийн нийт 122,010.3 мянган төгрөгөөр хэвийн зээлийн дүнг нэмэгдүүлсэн байна.

Бусад актив

	2004.12.31	2003.12.31
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	32,885.3	29,502.0
Авлага	2,000.0	13,680.0
Авлагын болзошгүй эрсдлийн сан	(2,000.0)	(2,000.0)
Үрьдчилж төлсөн татвар	27,682.8	4,032.2
Материал	18,717.4	16,413.2
БҮТЭЗ	-	-
Дүн (мянган төгрөгөөр)	79,285.5	61,627.4

2001 онд Дархан-Уул аймаг дахь салбарын касст тооллогоор дутагдсан 2,000.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэж эрсдлийн санг 100%-иар байгуулсан ба авлагыг данснаас хасах талаар шийдвэр гараагүй байна.

Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага өнгөрсөн мөн үеэс 2.8 хувиар буюу 838.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацааны эцэст байгууллагын орлогын албан татварын 27,682.8 мянган төгрөгийн илүү төлөлттэй байна.

Гүйцэтгэх захирлын 2004 оны 67 тоот тушаалын дагуу цаашид ашиглах боломжгүй болсон нийт 6.1 мянган төгрөгийн эд зүйлсийг актлаж данснаас хассан.

Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө

	2004.12.31	2003.12.31
Монголбанкинд төлөх өглөг	500,040.0	479,340.0
Харилцах	596,652.7	723,102.7
Байгууллагын	591,992.0	712,384.7
Иргэдийн	4,660.7	10,718.0
Хадгаламж:	1,558,230.6	1,811,274.5
Байгууллагын		
хугацаатай	192,719.7	227,061.1
хугацаагүй	-	160,000.0
Иргэдийн		
хугацаатай	1,289,461.0	779,226.2
хугацаагүй	76,049.9	644,987.2
Дүн (мянган төгрөгөөр)	2,654,923.3	3,013,717.2

Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр “Ажлын байр нэмэгдүүлэх” төслийн хүрээнд 2004 онд Монголбанкаас 555,500.0 мянган төгрөгийг хадгаламжийн хэлбэрээр авч байгууллага, иргэдийг зээлжүүлж, 534,800.0 мянган төгрөгийн зээлийг төлүүлж тайлант хугацааны эцсийн байдлаар 500,040.0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журам”-ын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн газрын 2003 оны 05-р сарын 28-ны өдрийн 20 тоот тогтооолоор 0.5 хувийн хүйтэй, 1 жилийн хугацаатай, 100,000.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг авч иргэд байгууллагыг зээлжүүлсэн.

Харилцах дансны 596,652.7 мянган төгрөгийн үлдэгдлийн 99.2%-ийг аж ахуйн нэгж байгууллагын, 0.8%-ийг иргэдийн харилцах эзэлж, нийт харилцах данс дахь хөрөнгийн үлдэгдлийн хэмжээ өнгөрсөн мөн үеийнхээс 126,450.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Нийт 1,558,230.6 мянган төгрөгийн хадгаламж байгаагийн 1,482,180.7 мянган төгрөг буюу 95.1%-ийг хугацаатай, 76,049.9 мянган төгрөг буюу 4.9%-ийг хугацаагүй хадгаламж эзэлж, нийт хадгаламжийн хэмжээ өнгөрсөн мөн үеийнхээс 253,043.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Бусад пассив

	2004.12.31	2003.12.31
Хүүгийн өглөг	57,896.0	53,271.0
Бусад өглөг	100,900.0	53,694.1
Дүн (мянган төгрөгөөр)	158,796.0	106,965.1

Бусад пассивын 36.4%-ийг хүүгийн өглөг, 63.6%-ийг бусад өглөг эзэлж байна.

Тус банкны нийт пассивын хэмжээ нь өнгөрсөн мөн үеийнхээс 9.84% буюу 306,963.0 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт пассивын 17.8%-ийг бусад банкнаас авсан зээл, 21.2%-ийг харилцах, 55.4%-ийг хадгаламж, 5.6%-ийг бусад пассив эзэлж байна.

Өөрийн хөрөнгө

	2004.12.31	2003.12.31
Дүрмийн сан	4,000,000.0	3,550,000.0
Нөөцийн сан	34,000.0	34,000.0
Нийгмийн хөгжлийн сан	11,930.3	11,930.3
Тайлант жилийн ашиг	31,832.8	169,306.5
Дүн (мянган төгрөгөөр)	4,077,763.1	3,753,306.5

Монголбанкны Хяналт шалгалтын газрын даргын 2004 оны 03-р сарын 10-ны өдрийн 6/517 тоот зөвшөөрлөөр банкны хувь нийлүүлэгчдийн бүтцийг өөрчлөлгүйгээр дүрмийн сангийн хэмжээг 450.0 сая төгрөгөөр нэмэгдуулсэн.

Орлого, зарлага

Тайлант хугацаанд нийт 1,236,036.9 мянган төгрөгийн орлого орсноос 82.1% буюу 1,014,801.7 мянган төгрөг нь хүүгийн орлого, үлдэх 17.9% буюу 221,235.2 мянган төгрөг нь банкны үйл ажиллагааны орлого байна.

Нийт 1,204,204.1 мянган төгрөгийн зардал гарснаас 19.1% буюу 230,425.1 мянган төгрөг нь хүүгийн зардал, 79.3% буюу 954,911.0 мянган төгрөг нь банкны үйл ажиллагааны зардал, 1.6% буюу 18,868.0 мянган төгрөг нь албан татварын зардал гарч 31,832.8 мянган төгрөгийн ашигтай ажиллажээ.

ҮТЕГ-ын харьяа Төвлөрсөн төсвийн орлого, хяналтын газрын Хяналт шалгалтын хэлтсээс тус банкны 2003 оны санхүүгийн үйл ажиллагаанд татварын ногдуулалт, төлөлтийн байдлыг шалгаж, 3,922.0 мянган төгрөгийн татварын нөхөн төлбөр ногдуулсныг төлж барагдуулсан ба энэ хэмжээгээр тайлант хугацааны ашгийг бууруулжээ.

Тайлангийн хугацаанд Зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санг Монголбанкнаас шинэчлэн гаргасан журмын дагуу байгуулсан, банкны чанаргүй зээлийн хэмжээ өссөн зэрэг нь үйл ажиллагааны зардал өсч, нийт үр дүн буурахад голлон нөлөөлсөн байна.

Шалгуур үзүүлэлт

Тус банк үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болох активт өөрийн хөрөнгийн эзлэх хувийн жин 73.8%, төлбөр түргэн түйцэтгэх чадварын зохистой харьцаа 61.8% байгаа нь Монголбанкны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

Тайлбар, тодруулгыг бэлтгэсэн:


Аудитор, ажлын хэсгийн ахлагч


Ж.Нэнгэлмаа, МНБ


Аудиторын туслах мэргэжилтэн


Т.Туяа

Аудиторын туслах мэргэжилтэн


Э.Өрнөл

Аудиторын туслах мэргэжилтэн


Б.Эрдэнэтамир